

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС 2024 ОНЫ
3 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ,
ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 10 дүгээр сарын 08

Арвайхээр

Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагуудад хандан ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2008 оны “Журам батлах тухай” 44 дүгээр захирамжийн хавсралтаар батлагдсан “Иргэдээс аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам”-ын хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж байна.


Иргэдээс 2024 оны 3 дугаар улирлын байдлаар аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагуудад хандаж нийт 9734 мэдэгдэл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График-1



Иргэдээс ирүүлсэн мэдэгдэл, гомдол, санал, хүсэлтийг байгууллагад хандаж ирүүлсэн сувгаар нь авч үзвэл: Биечлэн 5746, цахимаар 967, утсаар 317, албан бичгээр 2510, Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвөөр дамжуулан 194 мэдэгдэл, санал, гомдол, хүсэлт тус тус ирүүлсэн байна.

График-2




Иргэдээс ирүүлсэн нийт 9734 гомдол, хүсэлт, санал мэдэгдлийг төрлөөр нь авч үзвэл: Хүсэлт 9338 буюу 94,2 хувь, гомдол 336 буюу 3,4 хувь, санал 60 буюу 0.59 хувийг тус тус эзэлж байна.

Хүсэнгт-1

	2023 он	2024 он	Өсөлт, бууралтын харьцаа
Хүсэлт	13957	9338	49.4%
Гомдол	519	336	54.4%
Санал	0	60	100%
Мэдэгдэл	0	0	-

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар иргэдээс ирүүлсэн нийт 9734 өргөдөл, гомдол, мэдэгдэл, саналаас 5326 буюу 54.7 хувийг хуулийн хугацаанд биечлэн, 1305 буюу 13.4 хувийг утсаар, 702 буюу 7.2 хувийг цахимаар, 2268 буюу 23.2 хувийг албан бичгээр шийдвэрлэж иргэдэд эргэн хариу өгч ажилласан бөгөөд хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 1, шийдвэрлэх шатандаа 90 буюу 0.9 хувьтай байна. Мөн Харьяаллын дагуу болон Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн нийт 42 иргэний хүсэлтийг 3 дугаар улирлын хугацаанд шийдвэрлэсэн. өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1 хувиар буурсан байна.

шийдвэрлэсэн байдал

Аймгийн Засаг даргын Тамгын газар:

Аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн гомдол, мэдэгдэл, санал, хүсэлтийг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, иргэдийн санал хүсэлтийг тусгах, ил тод байдлыг хангах зорилгоор 7032-1111 дугаарын нээлттэй утсыг аймгийн Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвд ажиллуулж байна. Тус төвд хандаж ирүүлсэн саналт хүсэлтийн шийдвэрлэлтэд хариу өгсөн байдлыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлыг хүрээний удирдлагуудын нэгдсэн шуурхай хурлаар 7 хоног бүрийн мягмар гарагт тогтмол хэлэлцэж аймгийн удирдлагын зүгээс шаардлагатай үүрэг чиглэлийг өгч ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт хандаж энэ оны 3 дугаар улирлын байдлаар нийт 208 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн үүнээс биеэр 206 иргэний хүсэлтийг, албан бичгээр 2 иргэний хүсэлтийг тус тус хүлээн авсан. Шийдвэрлэлтийн хувьд: 2 иргэний хүсэлтийг албан бичгээр, 50 иргэний хүсэлтийг утсаар, 141 иргэний хүсэлтийг биечлэн шийдвэрлэж хариуг иргэдэд хүргүүлсэн. Иргэдээс ирүүлсэн нийт хүсэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.6 хувь буюу 68 иргэний хүсэлтээр өссөн үзүүлэлттэй байна.

Сумдын Засаг даргын Тамгын газар:

Сумдын Засаг дарга, түүний Тамгын газар, төсөвт байгууллагуудад нийт 8536 гомдол, мэдэгдэл, санал, хүсэлтийг хүлээн авснаас гомдол 271, санал 37, хүсэлт 8228 байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.8 хувиар буюу 4632 хүсэлтээр буурсан үзүүлэлттэй байна. Иргэдийн хүсэлтийг хүлээн авсан хэлбэрээр нь авч үзвэл: Биечлэн хүсэлт гаргасан 5245 иргэн, утсаар 307 иргэн, цахимаар 922 иргэн, албан бичгээр 1900, Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвөөс шилжүүлсэн 162 хүсэлтийг тус тус хүлээн авсан. Хуулийн хугацаанд нийт 8463 гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн байна. Мөн 32 иргэний хүсэлтийг төрийн байгууллагад харьяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэсэн. 41 иргэний гомдол, хүсэлт шийдвэрлэх шатандаа байна.

Сумдын өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдлаар нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний аентлаг:

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад нийт 990 санал, гомдол, хүсэлтийг иргэдээс ирүүлснээс 295 гомдол, санал, хүсэлтийг биечлэн, 10 хүсэлтийг утсаар, 45 гомдол, санал, хүсэлтийг цахимаар, 608 гомдол, санал, хүсэлтийг албан бичгээр, Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвөөс шилжүүлсэн 32 хүсэлтийг шилжүүлэн тус тус хүлээн авч шийдвэрлэсэн. Хуулийн хугацаанд нийт 946 гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн. 34 гомдол, санал, хүсэлт шийдвэрлэх шатандаа байна.

4

Иргэдээс ирүүлсэн нийт гомдол:

Өвөрхангай аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд 2024 оны 3 дугаар улирлын байдлаар иргэдээс 336 гомдлыг ирүүлсэн бөгөөд сумдын Засаг даргын Тамгын газар болон түүний төсөвт байгууллагад хандсан 271 гомдол, аймгийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад 64 гомдол тус тус ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах “11-11” төвд Өвөрхангай аймагтай хамааралтай нийт 68 гомдол ирсэнээс 3 дугаар улирлын байдлаар тус төвөөр дамжуулан 64 гомдлыг ажлын 2-7 хоногийн хугацаанд шийдвэрлэж үр дүнг, цахим системд байршуулан ажилласан байна. холбогдох төрийн байгууллагад 4 гомдлыг шилжүүлж, хуулийн хугацаанд шийдвэрлэх шатандаа судлагдаж байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР



**ИРГЭДЭЭС 2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СТАТИСТИК МЭДЭЭ**


Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
	1	2		3	4				5
Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн
Аймгийн Засаг даргын Тамгын газар	-	1	-	207	206	-	-	-	2
Агентлагууд		64	23	903	295	10	45	32	608
Сумдын Засаг даргын Тамгын газар		271	37	8228	5245	307	922	162	1900
Нийт	-	336	60	9338	5746	317	967	194	2510

2023 оны 3 дугаар улирлын байдлаар

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр

	1	2		3	4				5
Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	АНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн
Аймгийн Засаг даргын Тамгын газар	-	-	-	140	140	-	-	-	-
Агентлагууд	-	129	-	1039	1136	10	21		1
Сумдын Засаг даргын Тамгын газар	-	390	-	12778	11012	791	810	543	12
Нийт	-	519	-	13957	12288	801	831	543	13

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



2024 оны 3 дугаар улирлын байдлаар

ӨВӨРХАНГАЙ	Шийдвэрлэлтийн байдал									
	Шийдвэрлэж хариу өгсөн				Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй
	Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо				
1	2	3	4	5	6	7	8	9	10	
Аймгийн Засаг даргын Тамгын газар	2		50	141	-	-	-	-	15	-
Агентлагууд	514	14	49	369	1	9	-	-	34	-
Сумдын Засаг даргын Тамгын газар	1752	688	1206	4816	27	5	1	-	41	-
Нийт	2268	702	1305	5326	28	14	1	0	90	0

2023 оны 3 дугаар улирал харьцуулсан дүн

ӨВӨРХАНГАЙ	Шийдвэрлэлтийн байдал									
	Шийдвэрлэж хариу өгсөн				Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй
	Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо				
1	2	3	4	5	6	7	8	9	10	
Аймгийн Засаг даргын Тамгын газар	-	-	-	125	-	-	-	-	15	-
Агентлагууд	-	-	-	1133	4	-	-	-	31	-
Сумдын Засаг даргын Тамгын газар	-	-	-	12528	418	-	6	-	216	-
Нийт	-	-	-	13786	422	-	6	-	262	-

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ
ГАРГАСАН ГОМДОЛ (Агуулгаар)**

ӨВӨРХАНГАЙ	№	Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
	1	Боловсролын байгууллага үйл ажиллагаатай холбоотой	38	19.5	
	3	Орчны бохирдолтой холбоотой гомдол	93	9.3	
	5	Нийтийн тээвэр, гэрэлтүүлэгтэй холбоотой гомдол	21	7.5	
	6	Худаг, усан сантай холбоотой гомдол	28	3.02	
	7	Зам талбай, замын тэмдэг тэмдэглэгээ, гэрлэн дохио, гарцтай холбоотой	36	1.8	
	8	Бусад гомдол (Шар усны үер, үер устай холбоотой-21, эрчим хүчний уналттай холбоотой-10, 1 дүгээр ангийн элсэлттэй холбоотой-3, хөнгөлөлттэй өвс тэжээлд хамрагдаж чадаагүй тухай-1, орон сууцанд үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлж амгалан тайван байдал алдагдуулсан тухай-28, СӨХолбоотой хамааралтай гомдол-20, газрын өргөдөл авахгүй байгаатай холбоотой-2, айлын газар дээр зөвшөөрөлгүй буусантай холбоотой-2, хулгай их гарч байгаа тухай-2, өрхийн эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой-2)	91	22.1	
	9	Төрийн үйлчилгээ, төрийн албан хаагчтай холбоотой	29	8.6	
	10	Нийт	336	100	Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар сургалт мэдээлэл өгөх, арга зүй олгох

**2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ
ГОМДОЛ (Агуулгаар)**

ГАРГАСАН

ӨВӨРХАНГАЙ	№	Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
	1	Нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбоотой	44	8.4	
	2	Иргэний бүртгэл, мэдээлэл	80	15.4	
	3	Газар эзэмших, өмчлөх, шилжүүлэх	166	31.9	
	5	Тэтгэвэр тогтоолгох, тэтгэмж хүссэн	14	2.6	
	6	Хөдөлмөр эрхлэлт	32	6.1	
	7	Нийгмийн даатгал	22	4.2	
	8	Боловсролын асуудлаар	161	31.02	
	9	Нийт	519	100%	

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

